



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2021/48/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга бөгөөд

аудитын менежер: З.Мөнхбаяр

Утас: 327734

Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цогбаяр

Утас: 315558

Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn

Аудитор: Д.Нарантуяа

Утас: 325093

Цахим хаяг: narantuyad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
НӨАТ	Нэмэгдсэн өртийн албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6-8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9-11
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11-12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12-14
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14-15
3. Аудитын тайлан	16
3.1. Ерөнхий зүйл	16
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	16
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	17
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт	20
Залруулсан алдаа.....	20
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал.....	21-24
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.02.25 № 161
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Г.ЦЭРЭНДУЛАМ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>47,466,457.78</u>	<u>71,170,892.20</u>
33	АВЛАГА	-	89,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		89,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	47,466,457.78	71,081,892.20
351	Түүхий эд материал	12,852,529.43	32,449,886.85
35110	Тусгай зориулалттай материал	11,082,342.00	29,636,800.01
35130	Эм боох материал	1,770,187.43	2,813,086.84
354	Хангамжийн материал	34,613,928.35	38,632,005.35
35410	Бичиг хэргийн материал	756,300.00	522,400.00
35420	Аж ахуйн материал	2,149,210.00	1,484,660.00
35430	Сэлбэг хэрэгсэл	168,000.00	
35440	Түлш, шатах тослох материал	2,211,050.00	3,851,280.00
35450	Барилгын засварын материал	334,600.00	414,000.00
35460	Хүнсний материал	12,687,042.35	21,466,559.35
35470	Бусад хангамжийн материал	16,307,726.00	10,893,106.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>343,287,585.91</u>	<u>895,736,510.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	343,287,585.91	895,736,510.34
392	Биет хөрөнгө	343,287,585.91	662,216,490.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	292,069,728.16	541,743,891.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,928,573.62)	(36,224,244.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	73,312,687.12	145,162,637.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,442,141.74)	(51,650,550.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,142,356.40	85,892,356.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,369,470.41)	(23,210,599.15)
39217	Ном	503,000.00	503,000.00
393	Биет бус хөрөнгө	-	233,520,020.00
39301	Программ хангамж	682,000.00	682,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(682,000.00)	(682,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		233,520,020.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>390,754,043.69</u>	<u>966,907,402.54</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>131,987.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	131,987.00
413	Өглөг	-	131,987.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		89,000.00

4136	Бусад өглөг	-	42,987.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		42,987.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	390,754,043.69	966,775,415.54
51	Засгийн газрын хувь оролцоо	390,754,043.69	966,775,415.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	45,891,184.00	91,815,684.00
51101	Өмч: - төрийн	45,891,184.00	91,815,684.00
512	Хуримтлагдсан үр дүн	342,822,568.41	872,919,440.26
51210	Өмнөх үеийн үр дүн	84,887,086.21	342,822,568.41
51220	Тайлант үеийн үр дүн	257,935,482.20	530,096,871.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,040,291.28	2,040,291.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	390,754,043.69	966,907,402.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	737,153,100.69	1,131,154,773.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	273,846,540.69	541,119,633.00
120	Нийтлэг татварын бус орлого	273,846,540.69	541,119,633.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	273,846,540.69	541,119,633.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	273,846,540.69	541,119,633.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,306,560.00	590,035,140.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,064,760.00	104,761,540.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,524,760.00	9,321,540.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,400,000.00	39,025,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,250,000.00	56,415,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	890,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,241,800.00	485,273,600.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,241,800.00	485,273,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	479,217,618.49	601,057,901.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	479,217,618.49	601,057,901.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,105,850.32	593,265,686.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,152,989.00	255,208,744.00
210101	Үндсэн цалин	128,466,977.00	148,384,948.00
210102	Нэмэгдэл	63,312,312.00	73,905,012.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,373,700.00	21,777,000.00
210104	Урамшуулал		11,141,784.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,402,489.01	31,686,516.77
210201	Тэтгэврийн даатгал	18,655,128.44	23,224,995.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,126,957.06	2,156,599.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,663,004.59	1,831,702.30
210204	Ажилгүйдлийн даатгал	357,920.92	435,115.52
210205	Эрүүл мэндийн даатгал	3,599,478.00	4,038,104.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,792,646.28	31,688,653.64
210301	Гэрэл, цахилгаан	10,808,797.10	16,143,279.60
210302	Түлш, халаалт	12,143,969.09	8,374,298.57
210303	Цэвэр, бохир ус	5,839,880.09	7,171,075.47
2104	Хангамж, бараа материалын зардал	19,859,851.76	22,492,524.56
210401	Бичиг хэрэг	2,656,750.00	2,825,223.00
210402	Тээвэр, шатахуун	1,732,200.00	2,528,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,235,721.76	4,114,791.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,970,000.00	3,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,265,180.00	9,204,490.00
2105	Нормативт зардал	147,364,072.07	175,787,753.09
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,166,163.71	6,947,500.59

210502	Хоол, хүнс	118,032,308.36	139,605,852.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	27,165,600.00	29,234,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,400.00	4,105,300.00
210604	Урсгал засвар	92,400.00	4,105,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,446,250.00	31,219,885.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,606,850.00	31,219,885.99
210803	Даатгалын үйлчилгээ	806,400.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,995,152.20	41,076,308.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,104,000.00	1,477,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,100,000.00	254,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,791,152.20	39,345,208.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,111,768.17	7,792,214.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,770,000.00	2,740,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,770,000.00	2,740,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,341,768.17	3,252,028.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,341,768.17	3,252,028.03
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,800,186.50
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		1,800,186.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	257,935,482.20	530,096,871.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	257,935,482.20	530,096,871.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>467,881,560.00</u>	<u>591,108,140.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	467,881,560.00	591,108,140.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,639,760.00	105,834,540.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,524,760.00	9,321,540.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,400,000.00	39,025,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,825,000.00	56,415,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	890,000.00	1,073,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,241,800.00	485,273,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,241,800.00	485,273,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>458,552,560.00</u>	<u>586,358,140.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,552,560.00	586,358,140.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,810,791.83	578,365,925.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,152,989.00	255,165,752.07
210101	Үндсэн цалин	128,140,080.00	145,446,671.63
210102	Нэмэгдэл	63,598,431.00	77,833,925.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,414,478.00	20,789,389.67
210104	Урамшуулал		11,095,765.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,329,527.79	31,503,592.20
210201	Тэтгэврийн даатгал	18,753,397.56	22,089,575.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,999,887.38	2,598,774.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,597,723.11	2,038,699.10
210204	Ажилгүйдлийн даатгал	359,841.36	434,231.76
210205	Эрүүл мэндийн даатгал	3,618,678.38	4,342,311.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,150,396.28	31,668,503.64

210301	Гэрэл, цахилгаан	10,808,797.10	16,314,879.60
210302	Түлш, халаалт	10,501,719.09	8,182,548.57
210303	Цэвэр, бохир ус	5,839,880.09	7,171,075.47
2104	Хангамж, бараа материалын зардал	14,660,629.76	22,256,854.56
210401	Бичиг хэрэг	2,292,200.00	2,022,180.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	1,920,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,235,721.76	4,114,791.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,090,000.00	3,885,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,042,708.00	10,314,683.00
2105	Нормативт зардал	135,044,089.00	189,508,369.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.00	9,905,000.00
210502	Хоол, хүнс	113,248,039.00	148,385,369.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,796,050.00	31,218,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,880,160.00	44,246,353.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,910,760.00	44,246,353.50
210803	Даатгалын үйлчилгээ	806,400.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	163,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,093,000.00	2,016,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	993,000.00	1,762,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,100,000.00	254,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,741,768.17	7,992,214.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,400,000.00	2,940,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,400,000.00	2,940,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,341,768.17	3,252,028.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,341,768.17	3,252,028.03
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,800,186.50

213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		1,800,186.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,329,000.00</u>	<u>4,750,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,329,000.00	4,750,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,329,000.00	4,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,329,000.00	4,750,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,329,000.00	4,750,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,329,000.00)</u>	<u>(4,750,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	45,891,184.00	2,040,291.28	84,887,086.21	132,818,561.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,891,184.00	2,040,291.28	84,887,086.21	132,818,561.49
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			257,935,482.20	257,935,482.20
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,891,184.00	2,040,291.28	342,822,568.41	390,754,043.69
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	45,891,184.00	2,040,291.28	342,822,568.41	390,754,043.69

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,891,184.00	2,040,291.28	342,822,568.41	390,754,043.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	45,924,500.00			45,924,500.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			530,096,871.85	530,096,871.85
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,815,684.00	2,040,291.28	872,919,440.26	966,775,415.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	498,619,100.00	482,021,571.97	16,597,528.03	96.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	498,619,100.00	482,021,571.97	16,597,528.03	96.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	495,619,100.00	479,081,571.97	16,537,528.03	96.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,222,700.00	255,165,752.07	56,947.93	100.0
210101	Үндсэн цалин	143,547,500.00	145,446,671.63	(1,899,171.63)	101.3
210102	Нэмэгдэл	69,545,500.00	77,833,925.77	(8,288,425.77)	111.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,990,000.00	20,789,389.67	2,200,610.33	90.4
210104	Урамшуулал	19,139,700.00	11,095,765.00	8,043,935.00	58.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,455,100.00	31,503,592.20	2,951,507.80	91.4
210201	Тэтгэврийн даатгал	24,246,200.00	22,089,575.28	2,156,624.72	91.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,552,200.00	2,598,774.10	(46,574.10)	101.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,041,800.00	2,038,699.10	3,100.90	99.8
210204	Ажилгүйдлийн даатгал	510,400.00	434,231.76	76,168.24	85.1
210205	Эрүүл мэндийн даатгал	5,104,500.00	4,342,311.96	762,188.04	85.1

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,911,800.00	31,668,503.64	6,243,296.36	83.5
210301	Гэрэл, цахилгаан	17,560,300.00	16,314,879.60	1,245,420.40	92.9
210302	Түлш, халаалт	11,498,700.00	8,182,548.57	3,316,151.43	71.2
210303	Цэвэр, бохир ус	6,452,800.00	7,171,075.47	(718,275.47)	111.1
210304	Байрны түрээс	2,400,000.00		2,400,000.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,425,500.00	20,316,854.56	1,108,645.44	94.8
210401	Бичиг хэрэг	2,033,600.00	2,022,180.00	11,420.00	99.4
210402	Тээвэр, шатахуун	2,260,000.00	1,920,000.00	340,000.00	85.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,297,200.00	4,114,791.56	182,408.44	95.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,520,000.00	1,945,200.00	574,800.00	77.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,314,700.00	10,314,683.00	17.00	100.0
2105	Нормативт зардал	137,520,000.00	137,483,369.50	36,630.50	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210502	Хоол, хүнс	115,400,000.00	115,385,369.50	14,630.50	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,120,000.00	19,098,000.00	22,000.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,884,000.00	-	1,884,000.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,440,000.00		1,440,000.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00		180,000.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00		22,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00		242,000.00	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,200,000.00	943,500.00	4,256,500.00	18.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	689,500.00	310,500.00	69.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.00	254,000.00	3,946,000.00	6.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	2,940,000.00	60,000.00	98.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	2,940,000.00	60,000.00	98.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,940,000.00	60,000.00	98.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	498,619,100.00	482,021,571.97	16,597,528.03	96.7

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	498,619,100.00	482,021,571.97	16,597,528.03	96.7
132001	Орон нутгийн төсвөөс	498,619,100.00	482,021,571.97	16,597,528.03	96.7
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	19.00	19.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	19.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	19.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,834,540.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,834,540.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,034,353.50
2104	Хангамж, бараа материалын зардал	1,940,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,940,000.00
2105	Нормативт зардал	52,025,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,905,000.00
210502	Хоол, хүнс	33,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,996,353.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,996,353.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,073,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,073,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,800,186.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,800,186.50
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,800,186.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	105,834,540.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105,834,540.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,321,540.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,025,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,415,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,073,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Г.Цэрэндулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, И баримтын бүрдлийг хангах, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах, татвар суутгах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд НТАГ-ын аудитор Д.Нарантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг НТАГ-т 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Нийслэлийн хэмжээнд байгаа зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх мөн бие даасан амьдралтай болоход нь туслахад чиглэгдэнэ.

Тус төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийслэлийн хэмжээнд байгаа гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэх;
- Түр хоноглох байраар хангах;
- Нийгмийн халамжийн суурь үйлчилгээг үзүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийслэлийн Дотоод аудитын газраас 2020 онд хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шилэн дансны хуулийн хэрэгжилт болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 479,217.6 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 9,584.3 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 601,057.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 12,021.2 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардал өмнөх оноос 25.4 хувиар өссөнтэй холбоотой юм.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 576,153.4 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	89.00	89.00
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	47,466.40	71,081.89	23,615.49
Үндсэн хөрөнгө	343,287.60	895,736.50	552,448.90
Нийт хөрөнгө	390,754.00	966,907.39	576,153.39
Өр төлбөр	-	131.98	131.98
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	390,754.00	966,775.41	576,021.41
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	390,754.00	966,907.39	576,153.39

Авлага дансны үлдэгдэл 89.0 мянга болсон нь шинээр ХХОАТ-ын авлага үүссэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 71,081.9 мянган төгрөг болж 23,615.5 мянган төгрөгөөр өссөн нь ковид цар тахлын үед тус төвөөр үйлчлүүлэх иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой хоол, тусгай зориулалттай материал, шатахуун, эм амнэлгийн хэрэгсэл худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 966,907.4 мянган төгрөг болж 552,448.9 мянган төгрөгөөр өссөн нь тус төвийн барилгад 2019 онд хийгдсэн их засварын гүйцэтгэлээр 249,674.1 мянга сайжруулалт, дулааны узель, хяналтын камер, гадна цахилгааны кабельд 71,849.9 мянга, газар эзэмших эрхийн бүртгэл хийж 233,520.0 мянган төгрөгөөр газраа үнэлж, 32,000.0 мянган төгрөгийн 10 ш гэрийг тус тус бүртгэсэн. Үндсэн хөрөнгө данс нь 591,794.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, хөрөнгө хасагдаагүй байна.

Өр төлбөр данс үлдэгдэл 131.9 мянган төгрөг болсон нь татварын өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 966,775.4 мянган төгрөг болж 576,021.4 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 394,001.7 мянган төгрөгөөр буюу 53.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал болон нэмэлт санхүүжилт 24,664.8 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 267,273.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 121,840.3 мянган төгрөгөөр буюу 25.4 хувиар өссөн нь ковид цар тахалтай холбоотой хоол, тусгай зориулалтын материал, шатахуун, эмийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 572,391.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 572,391.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 73,773.4 мянган төгрөгөөр бууруулж 498,619.1 мянган төгрөгөөр баталсан нь нормативт зардлыг 46,600.0 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 31,000.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 9,420.0 мянган төгрөгөөр бууруулж, цалингийн зардлыг 22,168.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 498,619.1 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 485,273.6 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 482,021.6 мянган төгрөгийг зарцуулж 3,252.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 482,021.6 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2,951.5 мянга, тогтмол зардлыг 6,243.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,108.6 мянга, БГАҮТХ-ийн зардлыг 1,884.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,256.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Авсралийн элчин сайдын яамнаас хэрэгжүүлж буй төслийн үлдэгдэл санхүүжилт 9,321.5 мянга, НЗДТГ-аас 95,440.0 мянга, Нийслэлийн дотоод аудитын газраас тавьсан актын төлбөр 1,073.0 мянга/ *ажилчдаас авсан* / нийт 105,834.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс хоол хүнс, эм, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 52,025.0 мянга, хог хаягдал ариутгалын зардалд 1,940.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 48,996.3 мянга / *цалин, илүү цагийн хөлс, бараа материал, эд хогшил* /, нийт 104,034.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,800.1 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 96 мэдээллээс хугацаандаа оруулсан 86 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээлэл, мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээ байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,221.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	6,221.8	1	6,221.8	-	-	-
Нийт дүн	1	6,221.8	1	6,221.8	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,286.1 алдаа мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,865.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,544.2 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 9,876.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд өмнөх оны эргэлтийн бус хөрөнгийг 3,865.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 11,420.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,544.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1.Ээлжийн амралтыг бодохдоо унаа хоолыг оруулж тооцсоноос 1,544.2 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "... үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг..." заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоосон.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 9,876.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Ковид-19 цар тахлын хатуу хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотой цахимаар ажилласан болон цаг хугацаа хязгаарлагдсан байдлаас шалтгаалан зарим зардал болон хөрөнгийн үлдэгдэлд биет төстийн горимыг хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт:

- Дансны хуулга, И баримтыг тулган шалгахад тайлант хугацаанд хийгдсэн зарим худалдан авалтын төлбөрийн 7,742.3 мянган төгрөгийг И баримтгүй байхад (10 бэлтгэн нийлүүлэгч байгууллага И баримтыг цахим системд дутуу бүртгүүлсэн) шилжүүлсэн.

1.2. Эрсдэл:

- НӨАТ-ийн тухай хуулийг зөрсөн байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах; заалтыг хэрэгжүүлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг тухай бүр авч байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

2. Бараа материал холбоотой асуудал:

- 2.1 Илрүүлэлт: Тайланд онд худалдан авсан 2,050.0 мянган төгрөгийн хөрөнгийг (дэлгэц, чин зуух зэрэг) ангилал зөрүүтэй бүртгэж тайлагнасан.

2.2 Эрсдэл:

- Бараа материалыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй байх, холбогдох хууль, тогтоомж, стандарт, журам, заавар зөрчсөн байх;

2.3 Өгсөн зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх;" 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө" заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг залруулах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

3.Зардал данстай холбоотой асуудал:

3.1. Илрүүлэлт:

- Байгууллагаас олгож байгаа нэг удаагийн тэтгэмж урамшууллаас 84.0 мянган төгрөгийн татварыг суутгаагүй.

3.2 Эрсдэл:

- Холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг зөрчсөн байх,

3.3. Өгсөн зөвлөмж:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйл, "Албан татвар ногдох орлого", 7.1.2 "ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;" заалтыг хэрэгжүүлэн татвар суутган авах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

4.Шилэн данстай холбоотой асуудал:

4.1. Илрүүлэлт:

- Шилэн дансны мэдээллийг тулгахад 5 саяас дээш орлогын 1 гүйлгээ (1,000.0 мянган төгрөг) дутуу, зарлагын 5 гүйлгээг (5,337.3 мянган төгрөг) илүү мэдээлсэн нь андуурч шивсэн болон нэмэлт дансны гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалтын 1 гүйлгээг (171.6 мянган төгрөг) дутуу шивсэн.

4.2. Эрсдэл:

- Шилэн дансны тухай хууль, журам зөрчсөн байх;

4.3. Өгсөн зөвлөмж:

- Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв оруулж хэвших.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:

Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер

Аудитын менежер

Бэлтгэсэн:

Аудитор



З.Мөнхбаяр

А.Цогбаяр

Д.Нарантуяа

Шалгагдагч байгууллагын хариу:



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ**

Тоосгоны гудамж,
6 дугаар хороо, Сонгинохайрхан дүүрэг,
Улаанбаатар хот, 18060
Утас: 7028-1392, 7028-5748
<http://www.nhtt.ub.gov.mn>

2021.02.23 № 34
танай _____ -ны № _____ -т

「НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР」

2020 оны санхүүгийн тайланд хийгдэж буй аудитын асуудлын бүртгэлтэй танилцлаа. Цаашид өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



Нийгмийн Хамгааллын Тусгай Төв
Захиргаа
Дарга
Гэндэн Цэрэндулам
2021.02.23 17:36

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021.02.25			НТАГ-2021/48/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төв</i>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хөрөнгийг ангилал зөрүүтэй бүртгэсэн. Үүнд: нэг бүр нь 380.0 мянган төгрөгийн үнэтэй 5 ш чин зуух, дэлгэц зэргийг бараа материалд бүртгэж тайлагнасан.	2,050.0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Г.Цэрэндулам Б.Энхдолгор
2	Ээлжийн амралтын бодохдоо унаа хоолыг оруулж тооцсоноос 1,544.2 мянган төгрөгийг илүү олгосон.	1,544.2	Төлбөрийн акт	Дарга Нягтлан бодогч	Г.Цэрэндулам Б.Энхдолгор
3	Байгууллагаас олгож байгаа нэг удаагийн тэтгэмж урамшууллаас 84.0 мянган төгрөгийн татварыг суутгаагүй.	84.0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Г.Цэрэндулам Б.Энхдолгор
4	Шилэн дансны мэдээллийг тулгахад 5 саяас дээш орлогын 1 гүйлгээ (1,000.0 мянган төгрөг) дутуу оруулсан, зарлагын 5 гүйлгээг /56,672.2 мянган төгрөг/ илүү мэдээлсэн нь андуурч шивсэн болон нэмэлт дансны гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалтын 1 гүйлгээг /171.6 мянган төгрөг/ дутуу шивсэн.	-	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Г.Цэрэндулам Б.Энхдолгор
5	Дансны хуулга, И баримтыг тулган шалгахад тайлант хугацаанд хийгдсэн зарим худалдан авалтын төлбөрийн 7,742.3 мянган төгрөгийг И баримтгүй байхад (10 бэлтгэн нийлүүлэгч байгууллага И баримтыг цахим системд дутуу бүртгүүлсэн) шилжүүлсэн.	7,742.3	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Г.Цэрэндулам Б.Энхдолгор
6	Санхүүгийн байдлын тайланд өмнөх оны эргэлтийн бус хөрөнгийг 3,865.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.	3,865.6	Залруулга хийлгэсэн	Дарга Нягтлан бодогч	Г.Цэрэндулам Б.Энхдолгор
ДҮН		15,286.1			